



**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/106

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Засгийн газрын 2018 оны 40 дүгээр тогтоолоор баталсан Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн ажил дүгнэх журам”-ыг нэгдүгээр, “гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн ажил дүгнэх маягт”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн ажил дүгнэх журмыг хэрэгжүүлэхийг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гамшгийн шуурхай удирдлагын газар (хурандаа Б.Мандахгэрэл)-т даалгасугай.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

139  
Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2019 оны 07 дүгээр сарын 10-ны өдрийн  
А/106 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН АЖИЛ ДҮГНЭХ ЖУРАМ

### Нэг. Зорилго

1.1. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, ахлах байцаагч (цаашид "байцаагч" гэх)-ийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, Гамшгаас хамгаалах тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон холбогдох эрх зүйн хэм хэмжээний актын биелэлтийг хангуулах ажилд нь хяналт тавих, дүгнэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн ажлыг дүгнэх зорилт нь байцаагчийн сар, улирал, жилд хийсэн ажлын үр дүнг үнэлэх, үүрэг хариуцлага, мэдлэг чадварыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

### Хоёр. Зохион байгуулалт

2.1. Аймаг, нийслэлийн дүүргийг гамшгийн давтамж, цар хүрээ, хүн ам, дэд бүтэц, барилга байгууламжийн төвлөрөлөөр гурван зэрэглэлд хуваана. Үүнд:

2.1.1. нэгдүгээр зэрэглэлд: нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг;

2.1.2. хоёрдугаар зэрэглэлд: Дархан-Уул, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ, Ховд аймаг;

2.1.3. гуравдугаар зэрэглэлд: Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Завхан, Өвөрхангай, Увс, Сүхбаатар, Төв, Хөвсгөл, Хэнтий аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг;

2.2. Энэхүү журамд гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн эрхтэй Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, газрын дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, орлогч, хэлтсийн дарга, алслагдсан сумдын Гал түймэр унтраах, аврах ангийн захирагч нар хамаарахгүй.

### Гурав. Сард хийсэн байвал зохих ажил

3.1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг нэгдүгээр зэрэглэлд 20, хоёрдугаар зэрэглэлд 15, гуравдугаар зэрэглэлд 10 аж ахуйн нэгж, байгууллагад хийж, 70-аас доошгүй хувьд нь байцаагчийн эрх зүйн баримт бичиг (заавал биелүүлэх албан шаардлага, мэдэгдэл, танилцуулга, дүгнэлт, ажиллагаа зогсоох тогтоол)-ийг үйлдсэн байна.

3.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын хэрэг, зөрчил, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн бүртгэл хөтөлсөн байна.

3.3. Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг удирдамжийн дагуу цаг хугацаанд нь хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг зохион байгуулна.

3.4. Байцаагч нь дараах бүртгэл судалгааг хөтөлнө. Үүнд:

- 3.4.1. төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн шалгалтын материал;
- 3.4.2. байцаагчийн гаргасан эрх зүйн баримт бичгийн бүртгэл;
- 3.4.3. зөрчил шалган шийдвэрлэсэн материалын бүртгэл;
- 3.4.4. гамшиг, аюулт үзэгдэл ослын бүртгэл, судалгаа;
- 3.4.5. гамшгаас хамгаалах зориулалттай барилга, байгууламж, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн судалгаа (хоргодох, түр амьдрах байр, цугларах талбай, үерийн хамгаалалтын далан, суваг, нисдэг тэрэгний зогсоолын тоноглол, зарлан мэдээлэл дамжуулах техник хэрэгсэл гэх мэт)
- 3.4.6. дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалын төв, орон нутаг дахь хуваарилалт, зарцуулалтын бүртгэл;
- 3.4.7. орон нутгийн нөөц бүрдүүлэлт, нөхөн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтын бүртгэл, судалгаа;

### Дөрөв. Дүгнэх хугацаа, аргачлал

- 4.1. Байцаагчийн ажлыг сар бүрийн 25-ны өдрийн дотор төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга нар дүгнэж, баталгаажуулан Онцгой байдлын ерөнхий газрын гамшгийн шуурхай удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид албан бичгээр ирүүлнэ.
- 4.2. Байцаагчийн ажлыг дараах аргачлалаар дүгнэнэ. Үүнд:
  - 4.2.1. "төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт" гэсэн хэсгийг дүгнэхдээ шалгавал зохих байгууллагын тооноос шалгасан байгууллагын тоог харьцуулан хувилж тооцно. (1 дүгээр хүснэгт)
  - 4.2.2. "зөрчил" гэсэн хэсгийг дүгнэхдээ илрүүлсэн зөрчлөөс арилгуулсан зөрчлийн хувийг тооцно. (2 дугаар хүснэгт)
  - 4.2.3. "байцаагчаас гаргасан эрх зүйн баримт бичиг" гэсэн хэсгийг дүгнэхдээ байцаагчийн гаргасан баримт бичгийг шалгасан байгууллагын тоонд харьцуулж хувийг тооцно. (3 дугаар хүснэгт)
  - 4.2.4. "гүйцэтгэлийн шалгалт" гэсэн хэсгийг дүгнэхдээ байцаагчаас баримт бичиг гаргаж өгсөн байгууллагын хэдэн хувьд нь гүйцэтгэлийн шалгалт хийснээр хувийг тооцно. (4 дүгээр хүснэгт)
  - 4.2.5. "зөрчил шалган шийдвэрлэсэн байдал" гэсэн хэсгийг дүгнэхдээ илэрсэн зөрчлийг арилгуулахаар байцаагчаас иргэн, хуулийн этгээдэд гаргаж өгсөн баримт бичгийн биелэлтэд харьцуулж хувийг тооцно. (5 дугаар хүснэгт)
  - 4.2.6. "хяналт шалгалтын ажлын дундаж хувь"-ийг гаргахдаа 1, 2, 3, 4, 5 дугаар хүснэгтэд гарсан хувийн нийлбэрийг 5-д хуваана. Хяналт шалгалтын ажлын дундаж хувийг оноонд шилжүүлэхдээ дундаж хувийг авбал зохих 50 оноогоор үржүүлж 100 хувьд хуваана. (6 дугаар хүснэгт)
  - 4.2.7. "нэгдсэн арга хэмжээ" гэсэн хэсгийг дүгнэхдээ тухайн сард зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээнд хамрагдсан байдлаар хувиар тооцож авбал зохих 10 оноогоор үржүүлэн 100 хувьд хувааж оноог гаргана. (7 дугаар хүснэгт)
  - 4.2.8. "мэдээ, тайлан ирүүлсэн байдал" гэсэн хэсгийг дүгнэхдээ холбогдох мэдээ, тайланг хугацаанд нь ирүүлснээр хувиар тооцож, авбал зохих 10 оноогоор үржүүлж 100 хувьд хувааж оноог гаргана. (8 дугаар хүснэгт)
  - 4.2.9. "Байцаагчийн хөтөлбөл зохих баримт бичгийн бүртгэл" гэсэн хэсгийг дүгнэхдээ байцаагчийн 7 төрлийн баримт бичгийн хөтлөлтийн байдлаар хувь тооцож авбал зохих 30 оноогоор үржүүлж 100 хувьд хувааж оноог гаргана. (9 дүгээр хүснэгт)
- 4.3. Байцаагчийн сард хийсэн ажлыг нэгтгэн дүгнэхдээ батлагдсан маягтын 6-9 дүгээр хүснэгтийн онооны нийлбэрээр нийт оноог тооцно.
- 4.4. Байцаагчийн сард хийсэн ажлын нийт оноонд дүйцүүлэн дараах үнэлгээг олгоно. Үүнд:

90-100 оноо “А” буюу “Машсайн”;  
80-89 оноо “В” буюу “Сайн”;  
70-79 оноо “С” буюу “Хангалттай”;  
60-69 оноо “D” буюу “Дутагдалтай”;  
0-59 оноо “F” буюу “Хангалтгүй”;

#### Тав. Хариуцлага, хяналт

5.1. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга нарын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн ажлыг бодитой дүгнэсэн эсэхэд Онцгой байдлын ерөнхий газрын гамшгийн шуурхай удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж хяналт тавина.

5.2. Онцгой байдлын ерөнхий газрын гамшгийн шуурхай удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж байцаагч нарын ажлыг жилийн эцэст нэгтгэн дүгнэнэ.

5.3. Жилийн эцсийн дүнгээр “маш сайн” дүгнэгдсэн алба хаагчдыг урамшуулах, “хангалтгүй” дүгнэгдсэн албан хаагчид хариуцлага тооцох саналыг Гамшгаас хамгаалах улсын хяналтын ерөнхий байцаагчид уламжлан шийдвэрлүүлнэ.

\_\_\_оОо\_\_\_

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН АЖИЛ ДҮГНЭХ МАЯГТ

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
 2019 оны 07 дүгээр сарын 15-ны өдрийн  
 А/16 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Сард хийсэн ажлын үзүүлэлт

Аймаг, хотын нэр	Байцааг- чийн цол, овог нэр	Хяналт шалгалтын чиглэлээр																
		Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт			Зөрчил		Байцаагчаас гаргасан албан бичиг /70 хувь/			Гүйцэт- гэлийн шалгалт		Зөрчил шалган шийдвэрлэ- сэн байдал						
Архангай		Шалгавал зохих байгууллага Шалгасан байгууллага Хувь	Хүснэгт-1	Илрүүлсэн Арилгуулсан Хувь	Хүснэгт-2	ЗБАШ Мэдэгдэл Танилцуулга Дүгнэлт Ажиллагаа зогсоох тогтоол Хувь	Хүснэгт-3	Шалгасан байгууллага Хувь	Хүснэгт-4	Хэдэн удаа Хэдэн нэгжээр Хувь	Хүснэгт-5	Хяналт шалгалтын дундаж хувь Авбал зохих нийт оноо /50/ Авсан оноо	Хүснэгт-6	Хүснэгт-7	Хүснэгт-8	Хүснэгт-9	Нийт оноо	Үнэлгээ дүн
			Хүснэгт-1															
			Хүснэгт-1					Хүснэгт-2	Хүснэгт-3	Хүснэгт-4	Хүснэгт-5		Хүснэгт-7	Хүснэгт-8	Хүснэгт-9			

ДҮГНЭСЭН:

..... ДАРГА, /.....  
 (Байгууллагын нэр) (цол, гарын үсэг) (гарын үсгийн тайлал)  
 (огноо) /.....